



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХҮИИ.3.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 17,247.700,000 төгрөгөөр байхаар тогтоосон.

Иймд Нийгэмлэгийн шалган байцаах комиссын зөвлөмж болон “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн 10.в-д заасны дагуу Нийгэмлэгийн Ерөнхий хороо болон Хувь нийлүүлэгчдийн хурлаар 2019, 2020, 2021 оны үр дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг талаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын дарга Х.Хэрлэнд үүрэг болгож, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээг авахыг хувь нийлүүлэгчдийн хурлын гишүүдэд зөвлөмж болгох нь зүйтэй” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002524